

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн  
395 дугаар тогтоолын 25 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

#### Байгууллагын нэр

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар

#### Нэгжийн нэр:

Суурь судалгаа, мониторингийн хэлтэс

#### Албан тушаалын нэр:

Ой, усан сан бүхий газрын мониторинг, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

#### Ажлын цаг

Ажлын өдрийн 8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Барилгачдын талбай 3

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

#### Албан тушаалын зорилго:

Газрын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн сүлжээг байгуулах, байнгын ажиллагааг хангах, газар хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих, холбогдох мэдээллийн санг улсын хэмжээнд байгуулах, захиалгат хянан баталгааны дүгнэлтийг

баталгаажуулах, иновацид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах.

Албан тушаалын зорилт:

- Монгол Улсын хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын стратеги төлөвлөгөө, байгууллагын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан чиг үүрэг, заалтын хэрэгжилтийг хангах, холбогдох дүрэм, журам, стандарт, нормыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;
- Ойн болон усны сан бүхий газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үйл ажиллагаа эрхлэн дүгнэлт гаргасан мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд нь хяналт тавих, дүгнэлт өгөх, мэдээллийн санг хөтлөх;
- Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээний цэгийг байгуулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн санг хөтлөх, өөрчлөлтийг хянаж тогтоох, үр дүнг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, хариуцсан чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах;
- Газрын суурь, судалгаа мониторингийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчиний сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох, хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах, давтан сургах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;
- Суурь судалгаа болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн олон нийтэд үйлчилгээ үзүүлэх нехцэлийг бүрдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;
- Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд хариуцсан ажлын чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллах.

|                           |   |  |  |
|---------------------------|---|--|--|
| Зорилт                    | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг  | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт  | Хариуцаага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г, Хянах-X, Шийдвэрлэх-Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Монгол Улсын хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох чиг үүрэг, заалтыг хэрэгжүүлэх, тайлагнах;   | Холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.  | Г  |
|                           | 2. Салбарын стратеги төлөвлөгөө, байгууллагын стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан чиг үүрэг, заалтын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааны дунд болон богино хугацааны төлөвлөлтөд харицсан асуудлын чиглэлээр тусгах зорилт, арга хэмжээнд санал өгөх, хэрэгжүүлэх, тайлагнах; | Байгууллагын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, байгууллагын дунд болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна. | Г, Х   |
|                           | 3. Ойн болон усны бүхий газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн үйл ажиллагаатай   | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.   | Г, Х   |



|                           |   |  |      |
|---------------------------|---|--|------|
|                           | <p>холбоотой хууль тогтоомж, журам, заавар, арга зүй, аргачлал, дүрэм, журам, норм, стандарт, ажлын үнэлгээг шинэчлэх, боловсронгуй болгох санал боловсруулах, хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах;</p>  |  |      |
|                           | <p>4. Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны талаарх судалгаа, шинжилгээ хийх, иновцад суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх;</p>   | <p>Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан, судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байна.</p> | Г, Х |
|                           | <p>5. Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, нөхөн сэргээлтийн чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих.</p>  | <p>Судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байна.</p>   | Г, Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | <p>1. Хариуцсан асуудлын хүрээнд мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэлт гаргах, мэдээллийн санг хөтлөх.</p>  | <p>Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.</p>  | Г, Х |
|                           | <p>2. Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн тайлан, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт суурь, судалгаа, мониторингийн чиглэлээр хяналт шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах;</p>                       | <p>Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.</p>  | Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | <p>1. Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, мониторингийн улсын сүлжээг байгуулах, холбогдох мэдээллийн санг байгуулан хэвийг үйл ажиллагааг хангах;</p>  | <p>Тооцоо, судалгааг нь үнэн зөв гаргасан байна.</p>   | Г, Х |
|                           | <p>2. Бусад салбаруудтай хамтран улсын хэмжээнд ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээний цэгийг байгуулах, ус, херс, ургамал, байгаль цаг уурын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, харьцуулалт хийх, хяналт тавих, тайлагнах;</p> | <p>Орон зайн мэдээллийн сангийн шаардлагыг хангасан байна.</p>                                     |      |



|                           |  |  |      |
|---------------------------|--|--|------|
|                           | <p>3. Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтоож, үр дүнг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах;</p> | Үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан байна.                       | Г, Х |
|                           | <p>4. Мэргэжлийн байгууллагуудын хийсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлтийг ерөнхий шинжээчийн дүгнэлтээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;</p>  | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.                             | Г, Х |
|                           | <p>5. Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын мониторингийн ажилд агаар, сансрын зургийг ашиглах боломжийг бий болгох, боловсруулах, ашиглах;</p>  | Зайнаас тандан судлалын үйл ажиллагаа нэвтрэсэн байна.                 | Г    |
|                           | <p>6. Доройтол, талхагдал, бохирдолтод өртсэн ойн болон усны сан бүхий газрыг нөхөн сэргээх арга технологийн талаар судалж, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах, тайлاغнах;</p>   | Доройтол, талхагдал, бохирдолтод өртсэн газар нөхөн сэргээгдсэн байна. | Г, Х |
|                           | <p>7. Ойн болон усны сан бүхий газрын захиалгат хянан баталгааны ажлын мэдээллийн сан хөтлөх, хяналт тавих, дүн шинжилгээ хийх, тайлагнах;</p>   | Үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан байна.                       | Г, Х |
|                           | <p>8. Холбогдох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага болон гадаад орны төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, энэ чиглэлийн мэдээллээр хэрэглэгчдийг хангах;</p>   | Үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан байна.                       | Г, Т |
|                           | <p>9. Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанар, мониторинг, газар хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, үр дүнг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх.</p>   | Тооцоо, судалгааг нь үнэн зөв гаргасан байна.                          | Г    |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | <p>1. Хариуцсан асуудлын чиглэлээр мэргэжлийн боловсон хүчиний сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох, төлөвлөгөөнд санал боловсруулах;</p>   | Мэргэжилтэн, албан хаагчдын үр чадвар нэмэгдсэн байна.                 | Г.Х  |
|                           | <p>2. Хариуцсан асуудлын чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэх, давтан сургалтын материал бэлтгэх, удирдамж, төлөвлөгөө боловсруулах, батлуулах;</p>   | Мэргэжилтэн, албан хаагчдын үр чадвар нэмэгдсэн байна.                 | Г.Х  |



|                           |   |  |     |
|---------------------------|---|--|-----|
|                           | 3. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа болон бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах.  | Мэргэжилтэн, албан хаагчдын ур чадвар нэмэгдсэн байна.     | Г.Х |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1. Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоог гаргах, холбогдох төсөвт суулгах ажлыг зохион байгуулах;   | Тооцоо, судалгааг нь үнэн зөв гаргасан байна.              | Г   |
|                           | 2. Ойн болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанар, нөхөн сэргээлтийн мэдээллийн үнийг тогтоох, батлуулах, хэрэглэгчдэд хүргэх, үйл ажиллагаанд хяналт тавих;   | Холбогдох журамд нийцсэн байна.                            | Г   |
|                           | 3. Ойн болон усны сан бүхий газрын суурь судалгаа, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах;                                   | Шийдвэр гаргагчийг зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна. | Г   |
|                           | 4. Ойн болон усны сан бүхий газрын суурь судалгаа, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, мониторингийн бүх төрлийн мэдээллээр олон нийтэд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулах. | Олон нийтийг зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна.       | Г   |
| 6 дугаар зорилтын хүрээнд | 1. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дотоод ажлыг зохион байгуулах;  | Холбогдох журамд нийцсэн байна.                            | Г   |
|                           | 2. Салбарын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан ажлын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлын тооцоо, төсөвт тусгуулах санал боловсруулж, нэгжийн даргад танилцуулан, хэрэгжилтийг хангах;   | Холбогдох журамд нийцсэн байна.                            | Г   |
|                           | 3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, нэгжийн даргад танилцуулах, батлуулах;   | Холбогдох журамд нийцсэн байна.                            | Г   |
|                           | 4. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар, улирал, хагас жилээр нэгтгэж, нэгжийн даргад тайлагнах;   | Холбогдох журамд нийцсэн байна.                            | Г   |
|                           | 5. Үнэлгээний хороо болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах;   | Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.     | Г   |



|  |   |  |   |
|--|---|--|---|
|  | 6. Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан ажлуудыг тухай бүр зохицуулан зохион байгуулах, биелэлтийг хангаж, тайлagnah; | Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.               | Г |
|  | 7. Байгууллагын дотоод дүрэм, журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх;  | Дүрэм, журам ёс зүйн хэм хэмжээнд заасан манлайлал бий болсон байна. | Г |
|  | 8. Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд хүлээлгэн өгөх;  | Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна.                          | Г |
|  | 9. Байгууллагын болон нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, сургалт, олон нийтийн арга хэмжээнд оролцох.  | Албан хаагчийн мэргэжилийн ур чадвар нэмэгдсэн байна.                | Г |

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

|           |   |   |  |
|-----------|---|---|--|
| Боловсрол | -Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй  |   |  |
| Мэргэжил  | -газар зохион байгуулалт /-газрын кадастр, үнэлгээ менежмент, төлөвлөлт/ /0731-01/<br>-байгаль орчны ашиглалт, хяналт үнэлгээ /0712-03/ |   |  |
| Мэргэшил  | -Тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх                                   |   |  |
| Туршлага  | -Туслах түшмэлийн албан тушаалд эсхүл мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.  |   |  |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх  | <ul style="list-style-type: none"> <li>- орон зайн анализ, шинжилгээний програм хангамжийг ашиглан газар ашиглалтын суурь өгөгдөл, мэдээлэлд дүн шинжилгээ хийх</li> <li>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлagnah;</li> <li>- судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй;</li> <li>- бусад.</li> </ul> |  |
|           | Асуудал шийдвэрлэх  | <ul style="list-style-type: none"> <li>- өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;</li> <li>- шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах;</li> <li>- бусад.</li> </ul>   |  |
|           | Багаар ажиллах  | <ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> <li>- багийн хамт олны дунд хулээсэн үүргээ</li> </ul> |  |



|  |       |  |
|--|-------|--|
|  |       | <p>гүйцэтгэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- нээлттэй, шударга байх;</li> </ul>   |
|  | Бусад | <ul style="list-style-type: none"> <li>- MS Office-ийн програм хангамжийг бүрэн зээмшсэн байх;</li> <li>- ArcGIS, QGIS, Erdas imaging болон газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын програм хангамж ашиглаж өгөгдөл дүн шинжилгээ хийх чадвартай байх;</li> <li>-англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах.</li> </ul> |

#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

##### Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын орлогч дарга
- Нэгжийн дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

##### Бусад харилцах субъект:

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс

Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан

Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,  
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА



2019 оны 12 сарын 25-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19 12 25

Дугаар: 395



**VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:**

Байгууллагын нэр:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: ..... 2019.12.27 .....

Дугаар: ..... 5/191

(тамга/тэмдэг)

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр



Ц.ГАНХҮҮ

